



## “ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар хот

### “Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Оффисын ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Гагнуурчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.
3. Зааварчилгааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүй, аудитын алба /Л.Батбаяр/-д даалгасугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М.ГАНБААТАР

	Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТЦ-ТЗ04	БАТДЭВ ГҮЙЦЭТГЭН ЗАХИРАЛ И.М.Ганбаатар
		Хувилбар: 1	Багалсан огноо: 2020 он /...сар /19 өдөр
		Тушаал № А/162	

## СЛЕСАРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Өвөг нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-04	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 он ....сар .... өдөр
		Тушаал №	

# СЛЕСАРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-04
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-04
	Хувилбар: 1

## Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага .....	4
Хоёр. Ажил эхлэхийн өмнөх аюулгүйн шаардлага .....	4
Гурав. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны заавар .....	5
Ажил дууссаны дараах аюулгүй шаардлага .....	5

Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-04
	Хувилбар: 1

### **НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА**

- 1.1. Даралтат сав, шугам хоолойн ашиглалт, засварчин-слесарийн ажлын байранд холбогдох мэргэжлийн хүнийг ажиллуулна.
- 1.2. Даралтат сав, шугам хоолойн тоноглол угсралт, засвар, ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана.
- 1.3. Хийн тоног төхөөрөмжтэй ажлын байранд оч үсэрдэггүй багаж хэрэглэнэ. Ажлын шаардлагаар ган багаж хэрэглэх тохиолдолд түүнд тавот, литол эсвэл солидол зэргийг түрхэнэ.
- 1.4. Хийн тоног төхөөрөмжтэй ажлын байранд ил гал гаргах, шатах материал хадгалахыг хориглоно.

### **ХОЁР. АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА**

- 2.1. Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн зөв өмссөн байх.
- 2.2. Даралтат сав, шугам хоолойн технологийн процесстэй танилцаж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, аюултай ажил гүйцэтгэх наряд авч гарын үсэг зурна.
- 2.3. Хийн тоног төхөөрөмжтэй ажлын байранд шаардлагагүй хүн байлгахыг хориглох бөгөөд онгорхой хаалгаар гаднаас тасралтгүй хяналт тавих хүнийг томилсон байна.
- 2.4. Шуурхай ажиллагааны баримт бичиг, плакат, тэмдэг тэмдэглэгээ, цоож пайз байгаа эсэхийг шалгах.
- 2.5. Ажлын байрны гэрэлтүүлэг хангалттай эсэх, засвар хийх тоног төхөөрөмжид ачаалал хэр байгааг нягтлана.
- 2.6. Ажлын бүсээс шаардлагагүй хүмүүс, эд зүйлийг гаргаж, аюулгүй ажиллагааны тэмдэг байрлуулна.
- 2.7. Цахилгаан тоног төхөөрөмжийг засварт өгөхийн өмнө шугам дахь хүчдлийг цахилгаанчнаар хоёроос багагүй хэсэгт салгаж, хамгаалагчийг унтраалгасан байна. Удирдлагын түлхүүр дээр “Асааж болохгүй – хүмүүс ажиллаж байна” плакат, анхааруулах тэмдэг байрлуулна.
- 2.8. Ажил эхлэхийн өмнө дараах зүйлсийг шалгана. Үүнд:
  - Ажлын бүс, байранд хий алдагдаж байгаа, нэмэгдэж байгаа эсэх.
  - Ажлын байранд хийн эсрэг хэрэгсэл байгаа эсэх, ажиллагаа хэвийн эсэх.
  - Байгалийн агааржуулалт байгаа эсэх.
  - Дээрээс хатуу биет унах эрсдэлтэй эсэх.
  - Ажилд шаардлагатай багаж хэрэгсэл байгаа эсэх. Слесарь ашиглах зөвөөрөл аваагүй багаж хэрэгсэл, тоноглол, тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.

Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-04
	Хувилбар: 1

### **ГУРАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР**

- 3.1. Хийн тоног төхөөрөмжтэй байранд ажиллах үед онгорхой хаалгаар гаднаас тасралтгүй хяналт тавих ба гадны хүн оруулахгүй байх.
- 3.2. Хийн тоног төхөөрөмжийг задлах үед шилжүүлэх шугам дээрх салгаж байгаа төхөөрөмжийг хаалттай байрлалд, гадагшлуулах шугам дээр бол нээлттэй байрлалд байлгана. Салгасан хэсгийн үзүүрт хийн дээд даралтат тохирсон заглушк (төгсгөвч) хийнэ.
- 3.3. Хийн тоног төхөөрөмжийг бохирдол, механик гэмтлээс хамгаалах хэрэгтэй.
- 3.4. Хийн аппаратурын вентилийг нээх хаахад нэмэлт хөшүүрэг хэрэглэж болохгүй.
- 3.5. Регуляторыг ажиллаж байх үед боолтыг авч болохгүй.
- 3.6. Хийн тоног төхөөрөмжтэй ажлын байранд гагнуурын болон бусад галтай ажлыг ерөнхий инженерийн баталсан төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн аюулгүй нөхцлийг хангах арга хэмжээг заавал авч гүйцэтгэнэ.
- 3.7. Ажлын байранд хий нэмэгдэж байвал ажлыг шууд зогсоож хийн хоолойн бүх холболтуудыг шохойн эмульсээр шалгана.
- 3.8. Доголдыг өөрөө арилгаж чадахгүй бол яаралтай зогсоож, шууд удирдлагад мэдэгдэж осол гэмтлийг арилгах бригад иртэл нөхцөл байдалд хяналт тавих бөгөөд дур мэдэн ажлын байрыг орхин явахыг хориглоно.
- 3.9. Цахилгаан тасарсан, ажлын байрны гадна талд дуу чимээ үүсэн тохиолдолд ажлаа зогсоож, тоног төхөөрөмжийг унтрааж “Асааж болохгүй” плакат өлгөнө. Шууд удирдлагад яаралтай мэдэгдэнэ.

### **АЖИЛ ДУУССАНЫ ДАРААХ АЮУЛГҮЙ ШААРДЛАГА**

- 4.1. Тоног төхөөрөмжийг унтраахын өмнө хий өгөхөө зогсооно.
- 4.2. Ажлын байраа цэгцэлж, ашигласан материалыг хурааж хогийг зориулалтын хогийн саванд хийнэ.
- 4.3. Багаж хэрэгсэл, тоноглолыг зориулалтын шүүгээ саван хийж, хадгална.
- 4.4. Хувийн хамгаалах хэрэгслийг тайлж, хурааж, шүгээнд хийнэ.
- 4.5. Ажлын үед илэрсэн доголдол болон түүнийг арилгахаар авсан арга хэмжээний талаар шууд удирдлагад мэдээлнэ.